

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар: 01

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан даатгалын багц дүрмийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 3.4.2.6.ж, 2022 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”, Сангийн сайдын 2017 оны 1 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.5-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Үндэсний давхар даатгал” ХК-ийн “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.


2. “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-ын хэрэгжилтийг хангаж, холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн хороо (Я.Батханд)-нд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ



СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Үндэсний давхар даатгал” ХК (цаашид “компани” гэх)-ийн сонирхлын зөрчилтэй болон нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлох, сонирхлын зөрчилтэй этгээдтэй хэлцэл хийх үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.2. Энэ журам нь компанийн дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

1.3. Сонирхлын зөрчилтэй этгээдтэй хэлцэл хийхдээ Компанийн тухай хууль болон энэ журамд заасныг баримтална.

1.4. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1. “Эрх бүхий албан тушаалтан” гэж Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, дэд захирал, газрын дарга, санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогчийг;

1.4.2. “Ажилтан” гэж энэ журмын 1.4.1-д зааснаас бусад компанийн ажилтан, албан тушаалтныг.

1.5. Эрх бүхий албан тушаалтан нь дараах хугацаанд багтаан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг энэ журмын хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргаж, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (цаашид “НБД” гэх)-д өгөх үүрэгтэй:

1.5.1. Эрх бүхий албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор;

1.5.2. Энэ журам батлагдах үед ажиллаж буй эрх бүхий албан тушаалтнууд энэ журам батлагдсанаас хойш 10 хоногийн дотор;

1.5.3. Нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтад өөрчлөлт орсноос хойш 10 хоногийн дотор.

1.6. Компани эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангах үүрэгтэй.

1.7. НБД энэ журмын 1.5-д заасан үүргээ биелүүлээгүй эрх бүхий албан тушаалтанд шаардлага тавих, энэ талаар ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захиралд танилцуулж шийдвэрлүүлэх эрхтэй.

Хоёр. Сонирхлын зөрчил бүхий этгээд

2.1. Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь компанитай дор дурдсан харилцаанд орсон бол сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно:

2.1.1. Хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;

2.1.2. Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны (ногдол хувийн) 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

2.1.3. Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны (ногдол хувийн) 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

2.1.4. Хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

2.2. Дор дурдсан этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтан болон хувьцааны хяналтын багц эзэмшигчтэй нэгдмэл сонирхолтой этгээд гэж үзнэ:

2.2.1. Тэдгээрийн эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүн;

2.2.2. Тэдгээрийн эцэг, эх, хүүхэд, ач, зээ болон ах, эгч, дүү;

2.2.3. Тэдгээр нь өөрсдийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшдэг компанитай хийгдэж байгаа хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд уг гэрээнд оролцогч талууд.

Гурав. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тавих шаардлага

3.1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь ТУЗ-ийн НБД болон дотоод аудитын нэгжид дараах зүйлийг мэдээлэх үүрэгтэй:

3.1.1. Дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хуулийн этгээдийн болон түүний хараат болон охин компанийн талаар;

3.1.2. Өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг хуулийн этгээдийн болон тухайн этгээд оролцогч нь байдаг компанийн нэгдлийн бусад оролцогчийн талаар;

3.1.3. Компанийн хийхээр төлөвлөж байгаа хэлцлийн сонирхол бүхий этгээд болох тухайгаа;

3.1.4. Энэ журмын 2.1-д заасан этгээд өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаар.

3.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад оролцох эрхгүй.

Дөрөв. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх

4.1. Энэ журмын 2.1-д заасан этгээдийн өөрийн ажиллаж байгаа болон хувьцааных нь хяналтын багцыг эзэмшиж байгаа компанитай хийж байгаа хэлцлийг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэх ба сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар гаргана.

4.2. Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу ТУЗ тогтооно.

4.3. Дараах тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл (хоорондоо уялдаатай хэд хэдэн хэлцэл) хийх, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчид (цаашид "ХЭ" гэх)-ийн хурал гаргана:

4.3.1. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ-өөс тогтоосон хэлцлийн үнэ буюу эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрх, үйлчилгээний үнэ хөлс нь хэлцэл хийх тухай шийдвэр гаргах үеийн бүртгэлийн үнийн дүнгийн 25 хувиас их байх;

4.3.2. Компанийн гаргах энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдан авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны хэмжээ нь компанийн урьд нь гаргасан энгийн хувьцааны үнийн дүнгийн 25 хувиас их байх;

4.3.3. ТУЗ-ийн хараат бус бүх гишүүн нь хэлцэл хийх сонирхол бүхий этгээд байх.

4.4. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг ХЭ-ийн хуралд оруулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн олонхийн саналаар гаргана.

4.5. Хэлцэл хийх сонирхол бүхий этгээд, эсхүл түүний эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд, ах, эгч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдээс зээл авах тухай сонирхлын

зөрчилтэй хэлцэл хийхэд энэ журмын 4.3-т заасны дагуу шийдвэр гаргах шаардлагагүй.

4.6. Энэ журмын хоёрдугаар зүйлд заасны дагуу хэлцэл хийх сонирхол бүхий этгээдээр тооцогдохоос өмнө компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад байгуулагдсан сонирхлын зөрчилтэй хэлцлийг ХЭ-ийн дараагийн ээлжит хурал болох хүртэл энэ журмын 4.3-т заасны дагуу шийдвэр гаргах шаардлагагүй.

4.7. ХЭ-ийн хурал хийх өдөр компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад хийсэн хэлцлийг сонирхлын зөрчилтэй эсэхийг тодорхойлох боломжгүй бол ХЭ-ийн хурал нь хийх хэлцлийн төрөл, хэлцэл хийх этгээд болон хэлцлийн үнийн дээд хэмжээг тусгаж бусад этгээдтэй хамтран компанийн хэрэгжүүлэх аж ахуйн үйл ажиллагааг батлах шийдвэр гаргах бөгөөд энэ нөхцөлд энэ журмын 4.3-т заасан шаардлагыг хангасанд тооцно.

4.8. Гүйцэтгэх захирал сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар холбогдох судалгаа, дүгнэлтийг ХЭ-ийн хурал, ТУЗ-д танилцуулах үүрэгтэй.

4.9. Компани тухайн тайлангийн хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн талаарх мэдээллийг жилийн тайландаа тусган олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Тав. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас учирсан хохирлыг арилгах, хүлээх хариуцлага

5.1. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас компанид учирсан хохирлыг гэм буруутай этгээд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

5.2. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан энэ журмын 5.1-д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

5.3. Энэ журмын 2.1-д заасан этгээд нь энэ журмын гурав, дөрөвдүгээр зүйлийн шаардлага, зохицуулалтыг зөрчсөний улмаас компанид учруулсан хохирлын хэмжээгээр, эсхүл хэлцлийн үр дүнд авсан зүйлээс олсон ашгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

5.4. Энэ журмын 2.1-д заасан этгээдтэй байгуулсан хэлцлийг шүүх хүчин төгөлдөр бус гэж тооцож болно.

5.5. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 85 дугаар зүйл, энэ журмын 5.1-д заасны дагуу хариуцлага хүлээнэ.


5.6. Энэ журмын 2.1-д заасан этгээд нь энэ журмын гурав, дөрөвдүгээр зүйлийн шаардлага, зохицуулалт зөрчсөн, эсхүл компанитай хэлцэл байгуулсан хуулийн этгээдийн бүх хувьцааг уг этгээд дангаараа эзэмшдэг нөхцөлд компани нь учирсан хохирлыг тухайн хуулийн этгээдээр нөхөн төлүүлэх буюу энэ хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

5.7. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч, эсхүл компани нь энэ журмын 2.1-д заасан этгээд, эсхүл уг этгээдийн дангаараа бүх хувьцааг эзэмшдэг хуулийн этгээдээр компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр итгэмжлэлгүйгээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

5.8. Энэ журмын 5.5-д зааснаас бусад тохиолдолд энэ журмын дөрөвдүгээр зүйлд заасан зохицуулалт зөрчсөн бөгөөд уг зөрчлийн талаар энэ хэлцлийг байгуулсан этгээд мэдээгүй болон мэдэх боломжгүй байсан нөхцөлд уг хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцохгүй.

Зургаа. Бусад зүйл

6.1. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо энэ журмын хэрэгжилтэд хяналт тавина. Энэ журмыг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Эрсдэлийн хороогоор дамжуулан гаргана.



6.2. Компани энэ журамд тусгагдаагүй сонирхлын зөрчилтэй холбоотой аливаа асуудлыг Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид зааснаар шийдвэрлэнэ.

6.3. ТУЗ-ийн НБД, гүйцэтгэх захирал болон бусад эрх бүхий албан тушаалтнууд энэ журмын холбогдох зүйл, хэсэг, заалтыг мөрдөж ажиллана.

6.4. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулна.

Долоо. Журмын хавсралт

7.1. Хавсралт-“Үндэсний давхар даатгал ХК-ийн эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт”-ын загвар

---oOo---



ҮНДЭСНИЙ ДАВХАР
Сонирхлын зөрчилтэй хэлцэл
хийх журмын ХАВСРАЛТ

Mongolian Re
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛ

УЛААНБААТАР ХОТ
ТТГ6862 ☎ 5885612

**ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ НЭГДМЭЛ
СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙН ЖАГСААЛТ**

1. Ургийн овог: эцэг /эх/-ийн нэр:
өөрийн нэр: утасны дугаар:

2. Нэгдмэл сонирхолтой этгээд (Компанийн тухай хуулийн 89.2, 99.1-д заасныг дагуу өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаар бичнэ)

Д/д	Эцэг /эх/-ийн болон өөрийн нэр	Таны юу болох /эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, дүү, хүүхэд гэх мэт/	Одоо эрхэлж буй ажил /ажилладаг байгууллага, албан тушаал, сурдаг сургууль, анги гэх мэт/
1			
2			

3. Өөрийн болон нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр дээрх хуулийн этгээдийн талаар болон ямар нэгэн хуулийн этгээдэд хувь эзэмшдэг талаарх мэдээлэл

Д/д	Асуулга	Хэний нэр дээр байдаг /хуулийн этгээд болон хувьцаа эзэмшигчийн нэр, эзэмшиж буй хувьцааны тоо, хувь/	Хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар	Хуулийн этгээдийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэл	Байгуулагдсан огноо /хувь эзэмшиж эхэлсэн/
1	Та болон тантай нэгдмэл сонирхолтой этгээдийн нэр дээр хуулийн этгээд байдаг эсэх /харгалзах хүснэгтийн дагуу дэлгэрэнгүй, тодорхой бичих, хэрэв байдаггүй бол харгалзах хүснэгтэд "Үгүй" гэж бичих/				
2	Та болон тантай нэгдмэл сонирхолтой этгээд ямар нэгэн хуулийн этгээдэд хувь эзэмшдэг эсэх /харгалзах хүснэгтийн дагуу дэлгэрэнгүй, тодорхой бичих, хэрэв эзэмшдэггүй бол харгалзах хүснэгтэд "Үгүй" гэж бичих/				

4. Нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид ажилладаг эсэх

Д/д	Эцэг /эх/-ийн болон өөрийн нэр	Таны юу болох	Одоо эрхэлж буй ажил, албан тушаал
1			
2			

5. Та болон тантай нэгдмэл сонирхолтой этгээд компанитай бизнесийн аливаа хамааралтай эсэх, хамааралтай бол ямар:

ЖАГСААЛТ ГАРГАСАН:

.....

/албан тушаал/

.....

/гарын үсэг/

/

.....

/нэр/

---oOo---

